

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК Утас: 88114867 Цахим хаяг: shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 166

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмт наран" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмт наран" ОНӨААТҮГ-ын 2024 оны нийт зардлын гүйцэтгэлийн 43 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 7,2 хувийг цахилгаан эрчим хүч ашиглалттай холбоотой тогтмол зардал, 28 хувийг элэгдлийн зардал, 21,8 хувийг бусад зардал эзэлж байна.

Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмт наран" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

4525020232

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмт наран" ОНӨААТҮГ нь 2024 оны төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 60 ажил төлөвлөж, хэрэгжилт нь 89,3 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлднэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16,993,332.62	151,733,556.68
1.1.2	Дансны авлага	37,915,124.92	31,440,375.49
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	606,333.02	548,887.62
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.6	Бараа материал	60,357,067.3	76,269,305.90
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	115,871,857.86	259,992,125.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,719,982,027.50	2,514,122,656.50
1.2.2	Биет бус хөрөнгө	192,713,000.17	192,713,000.17
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,912,695,027.67	2,706,835,656.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,028,566,885.53	2,966,827,782.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	15,245,160.14	4,570,448.84
2.1.1.3	Татварын өр	81,934,672.46	34,200,422.41
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр	-	-
2.1.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	97,179,832.60	38,770,871.25
3	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	97,179,832.60	38,770,871.25
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	945,252,479.20	945,252,479.20
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	664,681,823.03	664,681,823.03
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,034,319,607.44	3,185,421,407.44
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,712,866,856.74)	(1,867,298,798.56)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,931,387,052.93	2,928,056,911.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,028,566,885.53	2,966,827,782.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Д/д	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	516,850,210.26	663,117,988.62
2	Борлуулалтын өртөг	273,255,659.78	330,736,289.19
3	Нийт ашиг (алдагдал)	243,594,550.48	332,381,699.43
4	Санхүүгийн дэмждэг орлого	184,765,454.55	462,139,272.72
8	Бусад орлого	44,652,429.10	18,899,727.28
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	863,386,083.54	967,825,404.10
11	Санхүүгийн зардал	90,874.00	27,237.15
12	Бусад зардал		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(390,464,523.41)	(154,431,941.82)
19	Орлогын татварын зардал	(390,464,523.41)	(154,431,941.82)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(390,464,523.41)	(154,431,941.82)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(390,464,523.41)	(154,431,941.82)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	824,389,381.00	1,259,607,321.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	571,134,940.00	711,686,666.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	203,242,000.00	508,353,200.00
	Бусад мөнгөн орлого	50,012,441.00	39,567,455.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	841,642,419.65	1,124,867,096.94
	Ажиллагчдад төлсөн	380,077,742.87	372,116,047.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	101,736,870.55	123,432,842.75
	Бараа материал худалдан авахад төлсөн	197,895,517.66	293,925,671.00
	Ашиглалтын зардалд төлсөн	115,734,291.90	104,072,411.85
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,824,692.92	24,974,301.75
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	60,914,908.75	180,623,480.36
	Даатгалын төлбөрт төлсөн		182,925.00
	Бусад мөнгөн зарлага	37,458,395.00	25,539,417.41
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,253,038.65)	134,740,224.06
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	700,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	700,000.00	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(17,953,038.65)	134,740,224.06
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,946,371.27	16,993,332.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,993,332.62	151,733,556.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,034,319,607.44	(1,712,866,856.71)	2,931,387,052.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,034,319,607.44	(1,712,866,856.71)	2,931,387,052.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
2023 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,034,319,607.44	(1,712,866,856.71)	2,931,387,052.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,034,319,607.44	(1,712,866,856.71)	2,931,387,052.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(154,431,941.82)	154,431,941.82)
Бусад дэлгэрэнгүй орлого			151,101,800		151,101,800
2024 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,185,421,407.44	(1,867,298,798.60)	2,928,056,911.11

2.5 Аудит хийсэн зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулааны борлуулалт	580,000,000.00	571,787,188.62	(8,212,811.38)	(1.44)
	Усны орлого	88,600,000.00	91,330,800.00	2,730,800.00	2.99
	Татаас, санхүүжилт /НӨАТ хассан дүн/	227,500,000.00	462,139,272.28	234,639,272.28	50.77
	Бусад орлого	-	18,899,727.00	18,899,727.00	100.00
	Нийт орлого	896,100,000.00	1,144,156,987.90	248,056,987.90	21.68
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	160,000,000.00	146,725,200.00	(13,274,800.00)	(9.05)
	Банкны шимтгэл	120000	27237.15	(92,762.85)	(340.57)
	Үндсэн цалин	458,716,550.00	492,242,769.43	33,526,219.43	6.81
	1 удаагийн тэтгэмж болон бусад	42,00000.00	2,477,400.00	(1,722,600.00)	(69.53)
	ХЧТүр алдсны тэтгэмж	1,500,000.00	800,000.00	(700,000.00)	(87.50)
	НДШ-ийн зардал	66,513,900.00	68,409,947.36	1,896,047.36	2.77
	Багаж техник, Засвар, үйлчилгээний зардал	26,350,000.00	35,149,692.50	8,799,692.50	25.03
	Шинжилгээний зардал	3,500,000.00	973,272.74	(2,526,727.26)	(259.61)
	Гэрэл цахилгааны зардал	120,000,000.00	94,611,283.50	(25,388,716.50)	(26.83)
	Зам ашиглалт зардал	4,500,000.00	2,181,818.19	(2,318,181.81)	(106.25)
	Интернет, шуудан холбоо	1,500,000.00	317,636.36	(1,182,363.64)	(372.24)
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	8,807,000.00	12,557,150.64	3,750,150.64	29.86
	Сургалтын зардал	4,500,000.00	3,170,000.00	(1,330,000.00)	(41.96)
	Нормын сүүний зардал	2,000,000.00	1,866,000.00	(134,000.00)	(7.18)
	Дотоод томилолтын зардал	1,000,000.00	1,014,000.00	14,000.00	1.38
	Ахмадын хүндэтгэл	1,000,000.00	351,000.00	(649,000.00)	(184.90)
	Тээврийн зардал /ковшийн түрээс/	7,750,000.00	4,050,000.00	(3,700,000.00)	(91.36)
	Элэгдлийн зардал	350,000,000.00	362,975,171.00	12,975,171.00	3.57
	Шатахууны зардал	19,500,000.00	19,149,323.01	(350,676.99)	(1.83)
	Үйл ажиллагааны бусад зардал	9,500,000.00	33,763,321.29	24,263,321.29	71.86
	Бичиг хэргийн зардал	1,300,000.00	728,916.49	(571,083.51)	(78.35)
	Вагон ашиглалтын зардал+ Вагон тээвэр	4,450,000.00	3,554,100.00	(895,900.00)	(25.21)
	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо зардал	1,000,000.00	647,425.00	(352,575.00)	(54.46)
	Үл хөдлөх хөрөнгийн татварын зардал	1,585,000.00	1,370,878.29	(214,121.71)	(15.62)
	Газрын төлбөр	1,000,000.00	2,020,166.00	1,020,166.00	50.50
	Ус рашаан ашигласны татвар	1,584,500.00	1,321,130.00	(263,370.00)	(19.94)
	Хөдөлмөр хамгааллын зардал	11,148,000.00	6,134,090.77	(5,013,909.23)	(81.74)
Зардлын дүн	1,273,524,950.00	1,298,588,929.72	25,063,979.72	1.93	
Ашиг/ алдагдал/	(477,427,900.00)	(154,431,941.82)	322,995,958.18	(209.15)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ нь Хонгор сумын оршин суугчид иргэд, аж ахуйн нэгжүүдэд дулаан үйлдвэрлэн хангах, цэвэр ус олборлон, цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах үндсэн үйл ажиллагаа явуулдаг

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон сууцны 107 өрх, 24 аж ахуй нэгжийг дулаанаар хангах
- Орон сууцны 107 өрх гэр хорооллын 110 өрх, 24 төсвийн болон бусад жижиг аж ахуй нэгжүүдийг цэвэр усаар хангаж бохир ус татан зайлуулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 10,11 дүгээр хавсралтын дагуу цалинд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-н 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Эмт наран” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод Монгол Улсын Засгийн газрын тогтоол болон Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Тайлант 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,739.12 мянган төгрөгөөр буюу 2,03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,993.3	151,733.5	134,740.2
Авлага	38,521.4	31,989.27	(6,532.13)
Бараа материал	60,357.0	76,269.3	15,912.3
Үндсэн хөрөнгө	2,912,695.0	2,706,835.6	(205,859.4)
Нийт хөрөнгө	3,028,566.9	2,966,827.78	(61,739.12)
Өр төлбөр	97,179.8	38,770.8	(58,409.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,931,387.0	2,928,056.9	(3,330.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,028,566.9	2,966,827.7	(61,739.2)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 134,740.2 мянган төгрөгөөр өссөн нь сумаас санхүүгийн дэмжлэгийн тодотголоор нэмэгдүүлж 277,373.9 мянган буюу 150 хувиар нэмэгдүүлэн санхүүжүүлсэнтэй холбоотойгоор өссөн. Энэ нь 2025 оны эхний санхүүжилт өгөхөөс өмнө нүүрс татан авалт тасалдахаас сэргийлэн урьдчилан арга хэмжээ авсан байна. Мөн авлага 6,532.1 мянган төгрөгөөр буурсан, бараа материал 15,912.3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Авлагын насжилтыг анхаарч авлага цуглуулалтыг анхаарч ажилласан байна. Бараа материал нь өссөн нь нүүрсний 10 хоногийн нөөцтэй, аж ахуйн материалыг аваарын нөөц бүртдүүлэх зорилгоор нөөц материал авсантай холбоотойгоор өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны анхны өртөг 157,101.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь УТХО болон ОНХС-ийн хөрөнгөөр 15,101.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансанд бүртгэж, авсан, өөрийн үйл ажиллагааны орлогоор 6,000.0 мянган төгрөгийн цахилгааны шугамын шон худалдаж авсан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 38,770.8 мянган төгрөг болж 58,409.0 мянган төгрөгөөр буурсан. Бүртгэсэн өр төлбөрөөс татварын өр 34,200.4 мянган төгрөгийг, бусад аж ахуйн нэгжид төлөх 4,570.4 мянган төгрөгийн өр төлбөр эзэлж байна. Өглөгийг байгууллага аж ахуйн нэгжүүдтэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Хуримтлагдсан ашиг 1,867,298.9 мянган төгрөг болж, 154,431.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдалтай холбоотой.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Эмт наран” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр 1,144,156.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,298,588.9 мянган төгрөгийн зардал гарган, 154,431.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,298,588.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 25,064,0 төгрөг буюу 2,0 хувиар хэтэрсэн нь сэлбэг материал, шатахууны үнэ цахилгааны хэрэглээ нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна. Тайлант хугацаанд цалин хөлс 2 удаагийн давтамжаар нийт 56 хувиар өссөн тул орон нутгаас авах татаас санхүүжилт 277,373.9 төгрөгөөр өссөн.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.1 Зардлын төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 151,101.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ОНХС-аас нийлүүлсэн.

Орон нутгийн төсвөөс 462,139.3 мянган төгрөгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын дагуу цалин нэмэгдүүлэхэд төсвийн тодотголоор 277,373.9 мянган төгрөгийн санхүүжилт нэмж олгосон байна.

3.5.2 Зардлын гүйцэтгэл

Тайлант оны төлөвлөсөн зардлыг 277,373.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. 2024 оны үйл ажиллагааг тогтвортой явуулах хүрээнд орон нутгаас 462,139.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Биелэлт
1	1-р худаг ухаалаг системд холбох, цахилгаан холболтын ажил	63,130,800	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн. Биелэлт-100%
2	Төв шугамын шинэчлэл	55,550,000	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн. Биелэлт-100%
3	Гүний худгаас усан сан хүртэл шугам хэсэгчлэн солих	7,839,700	ОНХС-ийн төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн. Биелэлт-100%
4	Зам хэсгийн худгийн ухаалаг төхөөрөмж	4,750,000	ОНХС-ийн төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн. Биелэлт-100%
5	Зуухны урд талын 1 дүгээр худгаас халуун усны хажуу талын худаг хүртэлх 5 хос шугамын шинэчлэл	19,831,300	ОНХС-ийн төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн. Биелэлт-100%

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Байгаль хамгаалах	2024.12.31		100	12,240.1	9,370.2

3.5.5 Худалдан авах ажиллагаа

“Эмт наран” ОНӨААТҮГ нь Орон нутгийн өмчийн газарт худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг хүргүүлж, цахим системд 16 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний худалдан 253,200,0 мянган төгрөгөөр худалдан авах төлөвлөгөөг мэдээлсэн. 2024 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг худалдан авах ажиллагааны цахим системээр илгээсэн байна.

Үүнээс 1 ТАХ-г НТШ-аар, 15 ТАХ-г шууд худалдан авалтаар зохион байгуулахаас 160.0 сая төгрөгийн нүүрс худалдан авах НТШ-ыг цахимд 2024 оны 02 дугаар сарын 26, 04 дүгээр сарын 08, 08 дугаар сарын 21-ний өдрүүдэд 3 удаа зарласан боловч тендерт оролцогч ирээгүй, галлагааны ажил эхлэх цаг тулсан учир үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөх нөхцөл байдал үүссэн шалтгаанаар тендерийн хороо 09 дүгээр сарын 11-нд хуралдаж, “Эмт наран” ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлд нөхцөл байдлыг шийдвэрлүүлэхээр өгсөн тул 09 дүгээр сарын 12-ны өдөр удирдах зөвлөлийн шийдвэрээр “Шарын гол” ХК-тай шууд гэрээ байгуулж, ажлаа эхлүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Л.Магсаржалам, компанийн захирал С.Оргил нар анхан шатны чанарын хяналтыг, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Эмт наран” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК-д 2025 оны 02 дүгээр сарын 25-ны өдрийн 14/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,136,733.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,734.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Эмт наран” ОНӨААТҮГ нь тээвэр шатахуун, урсгал засварын зардал, мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, цахилгаан эрчим хүчний хэрэглээг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 27 төрлийн 157 мэдээллээс 157 мэдээлэл оруулснаас 154 мэдээлэл хугацаанд нь оруулж 3 мэдээлэл хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан хэрэгжилт 98.9 хувьтай ба 6.1.1-д заасан тухайн жилийн байгууллагын батлагдсан төсөв 253,200.0 мянган төгрөгийг мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 6.1.3-т заасан тухайн байгууллагын дараа жилийн төсвийн төсөл 2,291,800.0 мянган төгрөгийг 1 хоногоор хугацаа хоцроож мэдээлсэн ба нийт 2,545,000.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн оруулж байх зөвлөмж өгөх.

4.4.2 Бусад хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглахгүй байгаа нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр

зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолын 1-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны лиценз бүхий баримт бичиг боловсруулах программ хангамж ашиглах арга хэмжээ хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй”, Цахим, хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бичиг хэрэг, шуудангийн зардлыг бууруулах зорилгоор албан бичиг солилцооны дундын системийг ашиглах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 50,118.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба 575.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 49,542.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	575.6	1	575.6	100.0
Зөвлөмж	4	49,542.8	4	49,542.8	100.0
Нийт дүн	5	50,118.4	5	50,118.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,591.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Тайлант онд албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

5.3.1. Илрүүлэлт:

Тайлант онд 4,591.9 мянган төгрөгийн худалдан авалт нь холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

5.3.1.2. Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг хийж, санхүүгийн тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, төлбөрийн баримтын цахим системд шивэгдээгүй байна.	1	4,591.9					1	4,591.9				
Дүн	1	4,591.9					1	4,591.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	3	2,545,000.0					3	2,545,000.0
Дүн	3	2,545,000.0					3	2,545,000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	3	2,545,000.0					3	2,545,000.0

ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмтнэран" ОНБААТТ

Тайлант хугацаа 2024 он

Хүснэгт А АГАДУТ-ын үндэслэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Нөлөөлж буй АГАДУТ	АГАДУТ-ийн дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Санхүүгийн тайлан	Бараа материалтай холбоотой асуудал	Дэлгэрэнгүй бүртгэлээс анхан шатны баримттай тулган баталгаажуулахад 4,591,937.0 төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна	4,591,937.00	Тийм	Үгүй	НББОУС-1	Хууль тогтоомжийн заалт	Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал	Зөвлөмж			
Дүн				4,591,937.00									

Бололтой бий АГАДУТ-ыг үндэслэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Тодорхойлсон зөрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Стандартын заалт	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Санхүүгийн тайланг УСНБОУС болон Төсвийн зуулийн 21.1 Монгол Улсын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд зөвсөн шаардлагууд болон Санхийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн болгосногүй байх	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 Монгол Улсын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардалыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны ливэн буюу баримт бичиг боловсруулах програмыг хангамж ашиглаж арга боловсруулж, цахим хэлбэрээр засгийн газрын өмчлөх, хэмээс хэрэгжүүлэхийг Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас үндэрдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэм" Цахим хөгжөөл харилцаа холбооны саядын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал"		Тийм	Үгүй	НББОУС-1	Хууль тогтоомжийн заалт	Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал	Зөвлөмж				
Дүн													

Бэлтгэсэн: Аудитор *Мунгун* Б.Хоролбат
Ханасан: *Мунгун* П.Магсаржалан
Цанарын хяналтын менежер *Мунгун* С.Оргил
Шинжлэн магадлахуй ЭЗШ-ийн *Мунгун* С.Оргил
Зөвлөх *Мунгун* С.Оргил



Огноо
Огноо

ААБ 5.6: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Хонгор сумын Зэмнэран ОНВААТГ
Тайлбарт хугацаа: 2024 он

Хүснэгт А. АГАДТ-ын үндсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Товчлолын нэр	Алдаа, зөрчлийн төвч утга	Мөнгөн дүн	Материалд өгсөж өгсөх	Үр өгсөж өгсөх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Асууцлын байгууллагын мэдээлэл	Асууцлын байгууллагын тайлбар	Гаргасан амлалт
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт				
1	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байх	Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан хэрэглээт 98.9 хувьтай ба 6.1.1 Тухайн жилийн Байгууллагын батлагдсан төсвөө 253,200,000.0 төгрөгийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	253,200,000.00	Тийм	Үгүй	УС-БЕОУС 24 "Саяонгийн тайлан дахь төсвийн мэдээллийн гадаргууга" 1 дэх хэсэг	Хууль тогтоомжийн заалт Шилэн дансны тухай хуулийн 6.1 "Энэ дараах мэдээллийг тогтмол мэдээлэх" 6.1.1 "Тухайн жилийн төсвийн жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдээлүүдийг хангалтгүй байна.		Зөвлөмж өгөх		
2	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байх	Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан хэрэглээт 98.9 хувьтай ба 6.1.3 Тухайн Байгууллагын дараа жилийн төсвийн төсөл 2,291,800,000.0 төгрөгийг 1 хоногоор хугацаа хоцорч мэдээлсэн байна.	2,291,800,000.00	Тийм	Үгүй	УС-БЕОУС 24 "Саяонгийн тайлан дахь төсвийн мэдээллийн гадаргууга" 1 дэх хэсэг	Шилэн дансны тухай хуулийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг тогтмол мэдээлэх" 6.1.3 "дараа жилийн төсвийн төсвийн жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдээлүүдийг хангалтгүй байна.		Зөвлөмж өгөх		
			2,545,000,000.0								

Бэлтгэсэн: *Могойба*
Аудитор: Б.Хорлолбат
Хянасан: *Могойба*
Цагарын хяналтын менежер: Л.Магсаржалан
Шинэсэн магадлахуй ЗЭД үйлэт ХХК-ийн захирал: С.Оргил



[Empty box for stamp or signature]